

ЦАХИМ ШУУДАНД

ХОЛБООЧДЫН ЦОГЦОЛБОР ТЭМЦЭЭНИЙ ШИЛДГҮҮД ТОДОРЛОО



Зэвсэгт хүчний холбооны цэргийн 100 жилийн ойг угтсан бүтээлч ажлын хүрээнд төр, цэргийн нэрт зүтгэлтэн хошууч генерал Р.Гаваагийн нэрэмжит Холбоочдын цогцолбор тэмцээн өнгөрсөн долоо хоногт цахим хэлбэрээр зохион байгуулав.

Тэмцээнд ХХЕГ, ОБЕГ, Зэвсэгт хүчний 013, 065, 124, 150, 186, 189, 325, 327, 331, 350, 353 дугаар ангийн 16 баг өрсөлдсөн юм.

Багийн дүнгээр тэргүүн байрт Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн 1 дүгээр баг 493,09 оноогоор, дэд байрт Хилийн цэргийн 0151 дугаар

анги 478,90 оноогоор, гутгаар байрт Зэвсэгт хүчний 124 дугаар ангийн 1 дүгээр баг 469,32 оноогоор шалгарсан бол Зэвсэгт хүчний 065 дугаар анги 460,09 оноогоор, Зэвсэгт хүчний 189 дугаар анги 417,18 оноогоор удаах байруудыг эзэллээ.

Өндөр хурдны радио телеграфчин төрөлд эрэгтэйчүүдээс сургагч ахлагч Ц.Болдбаатар/065/, хошууч Б.Мөнгөнзул /189/, ахлах ахлагч Д.Амарсайхан/189/, эмэгтэйчүүдээс ахлах ахлагч Ж.Цэрэнлхам/013/, ахлах ахлагч Н.Орлого /124/, хошууч С.Буяндэлгэр/0151/ нар тэргүүллээ.

Мөн электроникийн мэргэжилтэн төрөлд ахлах дэслэгч Ж.Бямбадорж /124/, ахмад Ц.Батзаяа /0151/, ахмад А.Волга/065/, Сүлжээний мэргэжилтэн төрөлд ахмад Батзул /189/, ахлах дэслэгч Ж.Бямбадорж /124/, ахмад Ц.Батзаяа /0151/, Эссэ бичлэгийн төрөлд хошууч Д.Ган-эрдэнэ/186/, ахлагч М.Ганцэцэг/327/, ахлах дэслэгч Л.Баттүвшин /331/ нар бусдыгаа манлайллаа.

АНУ-ЫН БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНААС МОНГОЛ ЦЭРГҮҮДЭД ТАЛАРХАЛ ИРҮҮЛЛЭЭ



АНУ-ын Батлан хамгаалахын Улс төрийн асуудал хариуцсан дэд сайдын Зүүн Азийн асуудал эрхэлсэн орлогч даргын үүрэг гүйцэтгэгч Давид Ф.Хэлвэе Монгол Улсын ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Д.Ганзоригт талархлын захидал ирүүлжээ. Захидалд “Эрхэм журмын нөхөр, дэслэгч генерал Д.Ганзориг танд болон Монгол Улсын Зэвсэгт хүчний нийт бие бүрэлдэхүүнд Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойн баярын мэндийг хүргэн мэндчилж байна. АНУ-ын Батлан хамгаалах яамнаас Монгол Улсын Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнээс Афганистан Улсад явагдсан НАТО-гийн цэргийн “Шийдвэртэй дэмжлэг” гэжээ.

болон “Аюулгүй байдлыг дэмжих олон улсын хүчин” зэрэг цэргийн ажиллагаануудад сүүлийн 18 жилийн хугацаанд хамтран үүрэг гүйцэтгэсэнд туйлын их талархаж байгаагаа энэхүү захидалаар илэрхийлжээ. Танай улсын Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчид ажиллагааны газар оронд үүрэг гүйцэтгэх үедээ мэргэжлийн өндөр ур чадвартайгаар байнга батлан харуулсан бөгөөд АНУ-ын хувьд хамгийн итгэж болох хариуцлагатай цэргийн хүчин гэж танигдсан. Уг ажиллагаа дуусгавар болсноор манай хоёр улсын цэргийн хамтын ажиллагааны нэгэн чухал хэсэг хаагдаж буй боловч нөгөө талаар шинэ хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлүүд бий болж байгаа гэдгээрээ онцлог байна. Монгол цэргүүдийн үүрэг гүйцэтгэлт, мэргэжлийн ур чадвар нь бидний хамтын ажиллагааг цаашид улам бэхжүүлэх хөшүүрэг болно гэдэгт эргэлзэхгүй байна. Монгол Улс, АНУ-ын цэргийн хамтын ажиллагааг цаашид улам үргэлжлүүлэх болно. АНУ-ын БХЯ-ны хамт олны нэрийн өмнөөс дэслэгч генерал Д.Ганзориг танд болон Монгол Улсын Зэвсэгт хүчний нийт бие бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэлт, эх орноо хамгаалах их үйлсэд нь өндөр амжилт хүсье. “Шийдвэртэй дэмжлэг” ажиллагаанд АНУ-ын Зэвсэгт хүчинтэй хамтран үүрэг гүйцэтгэсэн Монгол Улсын Зэвсэгт хүчний алба хаагч бүрд баярлалаа” гэжээ.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ БИЕ БҮРЭЛДЭХҮҮН, ТЕХНИК ХЭРЭГСЛИЙГ УЛСЫГ ХӨГЖҮҮЛЭХ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖИЛД ОРОЛЦУУЛАХ ЖУРАМ БАТЛАГДЛАА

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгын 2021 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн зарлигаар “Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцуулах тухай журам”-ыг баталсан юм.

Төр, засгаас эх орныхоо нийгэм, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангаж үйлдвэржүүлэх, дэд бүтцээ сайжруулах, иргэдийнхээ амьжиргааны орлогыг нэмэгдүүлэх, экологийн тэнцвэрт байдлаа хадгалах, бүс нутагт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрт нэгдэх бодлогын хүрээнд стратегийн ач холбогдол бүхий бүтээн байгуулалтын томоохон ажлуудад Зэвсэгт хүчнийг оролцуулж байна.

Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагууд бүтээн байгуулалтын ажилд оролцохдоо төрийн болон орон нутгийн удирдлага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, гадаадын зарим байгууллагатай хамтран ажиллах үед эрх зүйн харилцааг зохицуулах журмыг шинэчлэх шаардлагатай болсон юм. Энэхүү журмаар Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцуулах үйл ажиллагаа, үүнтэй холбоотой үүсэх харилцааг зохицуулагдана.

Журам нь Зэвсэгт хүчнийг бүтээн байгуулалтын ажилд оролцуулах оролцоо, арга, хэлбэр, удирдлага, зохион байгуулалт, бүх талын хангалт, Зэвсэгт хүчний анги, байгууллага,

аж ахуйн нэгж байгууллагуудын хүлээх үүрэг, хариуцлага бусад байгууллагуудтай харилцан ажиллах үндсийг тодорхойлсон тулгуур баримт бичиг юм.

Журмыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 01 дүгээр зарлигаар батлагдсан “Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцуулах журам”-ын үндсэн агуулгыг хэвээр хадгалж, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн стратеги, батлан хамгаалах салбарын хууль тогтоомжууд, бодлого зорилт, Зэвсэгт хүчний байгуулалтыг хөгжүүлэх урт, дунд хугацааны хөтөлбөр зэрэг хууль эрх зүйн актуудтай нийцүүлж, бүтэц, найруулгыг шинэчлэн, харилцан ажиллагааны үндсийг нарийвчлан тусгаж, 8 бүлэг, 37 заалттай болж шинэчлэгдсэн байна.

Журам батлагдсан нь дараах ач холбогдолтой гэж үзэж байна. Үүнд:

-Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцуулах үйл ажиллагаа, үүнтэй холбоотой үүсэх албан тушаалтан, чиглэл хариуцсан байгууллага хоорондын харилцаа, үүрэг, хариуцлага тодорхой болж, ажлын уялдаа холбоо, цогц байдал хангагдана.

-Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд батлан хамгаалах салбараас оруулах бодит

хувь нэмэр нэмэгдэж, Зэвсэгт хүчний хөгжлийг дэмжих эдийн засгийн боломж сайжирна.

-УИХ, Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч, Засгийн газар, Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Зэвсэгт хүчний Жанжин штаб зэрэг субъектүүдийн бүтээн байгуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаарх эрх үүрэг, хариуцлага оновчтой тодорхойлогдож, хариуцлагын тогтолцоо шинэчлэгдэнэ.

-Журмын давхардал арилж, стратегийн ач холбогдол бүхий бүтээн байгуулалтыг улсыг батлан хамгаалах шаардлагатай уялдуулах төрийн бодлого боловсронгуй болно.

-Нууцлал, аюулгүй байдлын өндөр стандарт шаардагдах төрийн болон цэргийн тусгай зориулалтын объект, байгууламжийг барих, засвар үйлчилгээ хийх ажлыг Барилга-инженерийн цэрэг болон Зэвсэгт хүчний бусад анги, байгууллагын хамтаар бие даан гүйцэтгэх чадавх бүрдэнэ.

Энэхүү журам

батлагдсаны дараа “Бүтээн байгуулалтын ажлыг зохион байгуулах дүрэм”-ийг Батлан хамгаалахын сайдаар, “Бүтээн байгуулалтын ажлыг зохион байгуулах журам”-ыг ЗХЖШ-ын даргаар тус тус батлуулахаар төлөвлөн ажиллаж байна.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ БАРИЛГА-ИНЖЕНЕРИЙН ЦЭРГИЙН УДИРДАХ ГАЗАР

АХЛАХ АХЛАГЧ Э.ДАВААЖАМЦ 1050 КМ ЗАМЫГ ТУУЛЖ, ӨВӨРХАНГАЙ АЙМАГТ ХҮРЭЛЦЭН ИРЛЭЭ



Өвөрхангай аймгийн ЗДТГ-ын Цэргийн шта

Цэрэгжлийн спортыг олон нийтэд сурталчлан таниулж, Монгол цэргийн эр зориг, тэсвэр хатуужлыг өөрөөрөө үлгэрлэн яваа Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн ахлах ахлагч Э.Даваажамц 24 дэх өдрөө буюу энэ сарын 25-ны өдрийн 19 цагт 1050 дахь км замаа туулж, Өвөрхангай аймагт ирлээ.

Ахлах ахлагч Э.Даваажамцыг Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалын Цэргийн сургалт, соёл хүмүүжлийн хэлтсийн дарга хурандаа Б.Батмөнх, Цэргийн штабын дарга, хурандаа М.Дэлгэрсайхан, Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн захирагч, дэд хурандаа Н.Гүрбадам, Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн дугуйн клубийн офицер, ахлагч нар угтан авч амар мэндийг нь мэдэж, гүйлтийн сонин сайхнаас нь хуваалцав. Түүнийг нэг өдөр амраад 6 дугаар сарын 26-ны өдрийн 16 цагт Онгийн голын хөвөөнөөс Өвөрхангай аймгийн Цэргийн штабын офицерууд,

Зэвсэгт хүчний 256, 113 дугаар салбарын удирдлага болон тус аймаг дахь ХААН банкны захирал Д.Энхбат, “Чин мэнд” эмнэлгийн захирал П.Чимгээ нар хүндэтгэл үзүүлэн үдэн гаргав.

Тус аймгийн ХААН банкны хамт олон ахлах ахлагч Э.Даваажамцын гүйлтийн замд нэн шаардлагатай уураг, эрдэс, амин дэм, зарим төрлийн эм тариагаар хангасан бол “Чин мэнд” эмнэлгийн хамт олон үнэ төлбөргүй үзлэг оношилгоо, шинжилгээ хийж, замдаа хэрэглэх шингэнээр хангаж, сэтгэлийн дэмжлэг үзүүлээ. Ахлах ахлагч Э.Даваажамц нартай, бороотой, шуургатай ч гүйсээр байна. Монгол цэргийн тэсвэр хатуужил, эр зоригийг өөрөөрөө харуулж яваа энэ залуу нь мэргэжлийн тамирчин биш бөгөөд жирийн л нэгэн алба хаагч юм.

Тэрээр өнөөдрийн байдлаар /07.30 цагт/ Өвөрхангай аймгийн Есөнзүйл сумын ойролцоогоос 1120 км-ээс 27 дахь өдрийн гүйлтээ эхэлж байгаа юм.

